

Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын хөгжилд магадлан итгэмжлэлийн шинжээчийн оролцоо

Цэрэндорж Цацрал*, Галиндэв Өлзийсайхан

Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль, Боловсролын удирдлагын тэнхим

* - Холбоо баригч зохиогч: tsatsral.tsetse@gmail.com
ORCID – <https://orcid.org/0009-0007-4297-7417>

Хүлээн авсан: 2024.01.02

Засварласан: 2024.04.08

Хэвлэлтэд авсан: 2024.05.03

Хураангуй

Дэлхий нийтэд 1980-аад оноос олширч эхэлсэн их дээд сургуулиудын сургалтыг чанаржуулах асуудлын нэг чухал алхам нь дээд боловсролын чанарын баталгаажуулалтын асуудал байв. 1980-аад оноос өргөн дэлгэрсэн чанарын баталгаажуулалт нь дэлхий дахинд өрнөсөн дээд боловсролын хамгийн чухал шинэчлэлийн нэг байсан бөгөөд энэхүү үйл явц олон улсын болон бүсийн чанарын баталгаажуулалтын байгууллагуудын дэмжлэгийг ихээр авч асар хурдан хөгжсөн байна. Манай улсад хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг нэвтрүүлэх ажил 1998 оноос эхэлсэн бөгөөд эхлээд их, дээд сургуулиуд байгууллагын магадлан итгэмжлэлд, дараа нь сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж эхэлсэн байна. Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаатай холбоотой судлаачдын судалгаа шинжилгээний ажил, тэр дундаа хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын шинжээчдийн тайлангийн талаарх судалгаа хийгдээгүй байна. Олон улсад хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тайлан, хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үр дүнг нээлттэй байлгах нь дээд боловсролд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой мэдээлэл болж байна. Энэхүү судалгааны ажлаараа дээд боловсролын хөндлөнгийн чанарын баталгаажуулалтад оролцож буй шинжээчдийн багийн тайланг судлахаар зорьсон. Судалгаанд Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагаар 2022 онд сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд ажилласан шинжээчийн багийн тайлангуудаас санамсаргүй түүврийн аргаар 20 тайланг сонгож авч шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнгээс харвал сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, сайжруулалтад хөтөлбөрт оролцогч талуудын (ажил олгогч, төгсөгч зэрэг) оролцоо дутмаг, магадлан итгэмжлэлийн шалгуурыг бүрэн хангахын тулд талуудаас судалгаа авдаг, хичээл хоорондын уялдаа холбоо муу, оюутны эрдэм шинжилгээний ажлын оролцоог дэмжих шаардлагатай зэрэг асуудлууд байна. Мөн сургуулиуд магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангахын тулд чанарын дотоод баталгаажуулалтын үйл ажиллагааг

тогтолцооны түвшинд бус хэрэглүүр төдий ашиглаж байгаа нийтлэг тулгамдсан асуудал байна.

Түлхүүр үг: Магадлан итгэмжлэл · Шинжээч · Шалгуур шаардлага Шинжээчийн тайлан

Удиртгал

Эдийн засгийн хурдацтай хөгжил, техник технологийн дэвшил, мэргэжлийн шинэ чиглэл, аж үйлдвэрлэлийн хувьсал зэрэг нь чанартай мэргэжилтэн бэлтгэхэд тусгайлсан шаардлагыг тавьж түүнийг дагаад дээд боловсролын эрэлт, нийлүүлэлт дэх чимээгүй хувьсгал үргэлжилсээр байна. Дэлхийн нийтийн хэмжээнд дээд боловсрол эзэмшигчид 2000 онд 100 сая орчим байснаа 2017 онд 221 сая болж 2 дахин нэмэгдэж (Martin, M. 2020, p. 6-7). 2040 он гэхэд дээд боловсролд хамрагдах оюутны тоо 660 саяас давах төлөвтэй байна (Calderon, 2018, p. 14). ЮНЕСКО-гийн IESALC тайланд дээд боловсролын хүртээмж сүүлийн хорин жилд 19%-аас 38% болж өссөн болохыг харуулсан (IESALC, 2020, p. 22). Манай улсын тухайд 2000 оны байдлаар 172 мянга гаруй суралцагч дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байсан бол 2020 оны байдлаар 148 мянга, 2030 онд 334 мянгад хүрэх төлөвтэй байна (Монгол Улсын Засгийн газар, Алсын хараа-2050) .

Дээд боловсрол эзэмшигчдийн хувь хэмжээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэхийн хэрээр дээд боловсролын чанарын асуудал чухлаар тавигдаж байна. Дээд боловсрол бол зөвхөн өөртөө биш нийгэмд үйлчилдэг механизм учраас дээд боловсролын чанарыг тасралтгүй сайжруулах ёстой. Сайжруулах гол хөшүүрэг бол чанарын баталгаажуулалтын үйл явц юм (БМИҮЗ, 2016, х.18). 1980-аад оны дунд үеэс хөгжиж эхэлсэн чанарын баталгаажуулалт нь дэлхий дахинд өрнөсөн дээд боловсролын хамгийн чухал шинэчлэлийн нэг байсан бөгөөд энэхүү үйл явц олон улсын болон бүсийн чанарын баталгаажуулалтын байгууллагуудын дэмжлэгийг маш ихээр авч хурдацтай хөгжиж өнөөгийн түвшинд хүрсэн байна (Чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын шинэ эрин, 2022, х.6)

Чанарын баталгаажуулалт нь дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалт гэсэн хоёр төрлөөр хөгжиж байна. Чанарын дотоод баталгаажуулалт нь тухайн дээд боловсролын сургалтын байгууллага өөрөө үйл ажиллагаагаа сайжруулахын тулд хийж буй тасралтгүй үйл ажиллагаа юм. Хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг урьдчилан тогтоосон шалгуур шаардлагын дагуу хөндлөнгийн эрх бүхий шинжээчийн баг ажиллаж дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх замаар дэлхийн улс орнууд зохион байгуулж байна (Leiber & Stensaker, 2018, p. 25).

Судлаач Shohreh et al. (2023, p.10) ISI, SID, PubMed, PubMed Central, Scopus, Web of Science зэрэг шинжлэх ухааны мэдээллийн санд индексжүүлсэн Перс, Англи хэл дээрх нийтлэлүүдийг “магадлан итгэмжлэл”, “чанарын баталгаажуулалт” болон “итгэмжлэл”, “чанарын баталгаа” гэсэн түлхүүр үгсээр хянаж, үнэлсэн бөгөөд тэдний судалгааны ажлын үр дүнгээр чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн системийг ашиглах нь дэлхийн ихэнх дээд боловсролын байгууллагуудын амжилтад хүрэх замыг нээж өгч байгаа

төдийгүй томоохон өсөлтийг харуулсан байна. Боловсролын байгууллагуудад сургалтын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад гарсан дутагдлыг залруулах, урьдчилан таамаглах, бэрхшээл гарахаас нь өмнө чанарын баталгаажуулалтаар оношлох нь маш сайн механизм болохыг энэхүү судалгаагаар хийсэн үр дүн харуулсан байна. Мөн судлаач нар олон улсын магадлан итгэмжлэл нь өндөр амжилт гаргах, гүйцэтгэлийг сайжруулах эерэг хөшүүрэг болж байгааг онцолсон байна.

Монгол улсад ч мөн боловсролын магадлан итгэмжлэх төв байгууллагаас тогтоосон шалгуур, шаардлага /стандарт/-ын дагуу сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөр, сургалтын шинэ хөтөлбөрт бие даасан, хараат бус шинжээчид хөндлөнгийн үнэлгээ хийж, ахиц дэвшлийг дэмжин, мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрч, чанарын баталгаажуулалт хийх замаар чанарыг хангах, сайжруулах үйл ажиллагаанд оролцож байна (Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, шаардлага батлах тухай, 2018).

Манай улсын хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг магадлан итгэмжлэлээр зохион байгуулсан 26 жилийн туршлага байна. Гэсэн хэдий ч энэ хугацаанд магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой хийж байсан судалгаа шинжилгээний ажил бага, хангалтгүй байна. Судлаач Б.Соёлмаа нарын дээд боловсролын бакалаврын сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтад магадлан итгэмжлэлийн 7 шалгуур 26 дэд шалгуур бүхий хувьсагчийг ашиглан 2018-2022 онд магадлан итгэмжлэгдсэн Инженерчлэлийн хөтөлбөрүүдээс бакалаврын 25 хөтөлбөрийн тухайн шалгуурыг хэрхэн хангаж буй байдалд дүн шинжилгээг SURE үнэлгээний аргыг ашиглан хийсэн бол судлаач Г.Орхон (2018, х.91-95) боловсролын чанарын соёлын өнөөгийн байдалд дүн шинжилгээ тус тус хийсэн байна. Эдгээр судалгаанууд нь чанарын баталгаажуулалтын шалгуур, шаардлага, болон төлөвшлийн хүрээнд хязгаарлагдаж байна.

Манай улсын тухайд магадлан итгэмжлэх үйл ажиллагааны мэдээлэл ялангуяа сургууль, сургалтын хөтөлбөрт ажилласан шинжээчдийн тайлан нь төдийлөн судалгааны эргэлтэд ордоггүй. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэж буй өөрийн үнэлгээний тайлан, шинжээчдийн өгсөн зөвлөмж, дүгнэлт, тайланг судлах, олон нийтэд нээлттэй болгох нь дээд боловсролын салбарын үйл ажиллагааг сайжруулахад төдийгүй нийгэмд дээд боловсролын чанарт итгэх итгэлийг төрүүлэхэд чухал ач холбогдолтой.

Тэгвэл эсрэгээрээ Европын их сургуулийн холбооноос 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын шинжээчдийн тайланг олон нийтэд нээлттэй болгож, ил тод байдлыг харуулж, дээд боловсролын чанарт итгэх итгэлийг бий болгох зорилгоор Европын дээд боловсролын чанарын баталгаажуулалтын бүртгэл (EQAR)-ын санд 56 орны 1624 байгууллагын чанарын баталгаажуулалтын 9754 тайланд хандах боломжийг олгосон байна. Энэхүү санд магадлан итгэмжлэл, үнэлгээ, үр дүнд, албан ёсны шийдвэр зэрэг үндсэн мэдээллээс гадна, тайланг бүрэн эхээр нь татаж авах боломжийг хэрэглэгчдэд олгодог байна. Ингэснээр энэ мэдээллийн сан нь байгууллагууд болон тэдний сургалтын хөтөлбөрийн талаарх бодит мэдээллийг олж авах боломжийг хэн бүхэнд олгоно гэж үзжээ (Tücek, 2019, p.15).


Энэхүү судалгааны ажил нь магадлан итгэмжлэх үйл ажиллагааны шинжээчдийн багийн тайлангийн анхаарах асуудал зөвлөмжийг судлах замаар дээд боловсролын сургалтын хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаанд анхаарах асуудлуудыг нээлттэй болгож энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлын цаашдын чиглэлийг судлаачдад дэвшүүлэх, гүнзгийрүүлэн судлах судалгааны чиглэлийг олж тогтоох, их дээд сургуулиуд хөтөлбөрийн төлөвлөлт, сургалтын үйл ажиллагаа, суралцагчид чиглэсэн үйл ажиллагаагаа цаашид сайжруулахдаа тус судалгааны үр дүнг ашиглаж болно.

Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тухай:

Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын үйл явцыг чанарын дотоод баталгаажуулалт ба чанарын хөндлөнгийн баталгаажуулалт гэж ангилна. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын дотооддоо авч хэрэгжүүлсэн чанарын баталгаажуулалтын арга хэмжээнүүдийн (чанарын дотоод баталгаажуулалт) үр дүнд чанарын баталгаажуулалтын зорилгодоо хүрсэн ололт амжилтаа эрх бүхий хөндлөнгийн байгууллагаар (хөндлөнгийн чанарын баталгаажуулалт) магадлан шинжилж, хянаж, аудит хийх байдлаар хөндлөнгөөс чанарыг баталгаажуулах юм (Дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын зөвлөмж, 2016, х.55).

Зураг 1

Дээд боловсрол дахь гадаад ба дотоод чанарын баталгаажуулалт (БМИҮЗ, 2018)



Хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг Монгол улсад Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (цаашид БМИҮЗ гэх) 1998 оноос урьдчилан тогтоосон шалгуур шаардлагын дагуу сургалтын байгууллагын, сургалтын хөтөлбөрийн, хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл (шинээр нээж буй хөтөлбөрт хамаарна) хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Чанарын дотоод баталгаажуулалтыг их дээд сургуулиуд өөрсдийн онцлогт тохируулан харилцан адилгүйгээр хэрэгжүүлж байна. Ингэхдээ чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, оролцогч талуудын сэтгэл ханамжийн үнэлгээг хийх түүнд тулгуурлан сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрөө сайжруулах, байгууллагын хэмжээнд чанарын соёлыг түгээх,

сайжруулалтын арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Дээд боловсролын салбарын хөгжил, үе, шат, чанарын баталгаажуулалтын өнөөгийн байдлыг үечлэн үзүүлбэл:

- Хямралын үе - 1985-1995 (улс орны хувьд нийгмийн өөрчлөлт хүчтэй явагдсан үе)
- Тооны өсөлтийн үе - 1995-2013, (хувийн өмчийг хүлээн зөвшөөрснөөр маш олон дээд сургуулиуд байгуулагдсан. Энэ үед их, дээд сургуулийн тоо 150 давж байв)
- Чанарын өсөлтийн үе- 2014-2022 тодруулах (Тооноос илүү чанарт анхаарч, хууль эрх зүйн орчны шинэчлэл, магадлан итгэмжлэл, аттестатчилал, төрийн бодлогоор дамжуулан сургалтын чанарт анхаарах болов. Ингэснээр их, дээд сургуулийн тоо 67-д хүрэв) гэж ангилж болно.

Дээрх сургууль, сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг урьдчилан тогтоосон шалгуур шаардлагаар дамжуулан хөндлөнгийн мэргэжлийн шинжээчдийг ажиллуулах замаар зохион байгуулж байна. Сургууль, сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх дундаж хугацаа 6-8 сар байх бөгөөд өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэх эсэх шийдвэр гаргах гэсэн 3 үе шат бүхий үйл ажиллагааг талууд хамтран ажиллах гэрээний дагуу зохион байгуулдаг (БМИҮЗ, 2023, х.18).

2018 оноос эхлэн энэхүү үндсэн 3 шатлалт үйл ажиллагаа дээр чанарыг тасралтгүй сайжруулах буюу ахиц дэвшлийг 2 жил тутамд хэмжих үе шат нэмэгдсэн. Өмнө нь сургуулиуд 10 жилийн хугацаатай магадлан итгэмжлүүлж, магадлан итгэмжлэлийн хугацаа дуусах дөхмөгц шинжээчдийн өгсөн зөвлөмжийг анхаардаг зэрэг сул талтай байсан бол магадлан итгэмжлэлийг 5 жилийн хугацаатай болгож, 2 жил тутамд ахиц дэвшилд үнэлгээ хийдэг болсноор дээд боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөр чанараа тасралтгүй сайжруулахад чухал нөлөө үзүүлж байна. Энэ чанарын цикл нь эерэг сайн нөлөө үзүүлж байсан ч 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан “Дээд боловсролын тухай” хуульд байгууллагын магадлан итгэмжлэлийг 10 жил тутамд хийхээр заасан нь сөрөг нөлөө үзүүлж болох юм. Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт буюу магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд чухал байр суурь эзэлж буй хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийн тухай ойлголтыг тодруулья:

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2017 оны 09 тоот тогтоолоор (www.mnsea.edu.mn, 2017) шинжээчийн баг нь 3-5 гишүүнтэй байх бөгөөд боловсролын удирдах ажилтан (байгууллагын магадлан итгэмжлэл), профессор багш-судлаач, ажил олгогч-мэргэжлийн холбоо, оюутан-суралцагч байхаар заасан. Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон шинжээчийн багийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүйгээ нотолж нууцлалын гэрээг байгуулдаг.

Шинжээч нь их дээд сургуулийн багшийн төлөөлөл бол доктор зэрэгтэй байхыг шаарддаг. Мөн дээр дурдсанчлан шинжээчийн багийн гишүүд тухайн сургалтын хөтөлбөртэй ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой. Ашиг

сонирхлын зөрчилд тухайн сургалтын хөтөлбөр, тухайн сургуульд сүүлийн 5 жилд багшлаагүй байх, ямар нэг байдлаар цалин урамшуулал аваагүй байх, гэр бүлийн хүн, хүүхэд нь ажиллаж суралцдаггүй байх, тухайн сургууль, сургалтын хөтөлбөрийг суралцаж төгсөөгүй байх зэрэг шаардлагыг тавьдаг.

Шаардлагыг хангаж томилогдсон шинжээчийн багт магадлан итгэмжлэх байгууллагын зохицуулагч мэргэжилтэн сургалт хийж магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, шалгуур шаардлага, шинжээчдийн баримтлан ажиллах журам, ажиллах хуваарь зэрэг гол зарчмуудыг тайлбарлан таниулдаг. Магадлан итгэмжлэх байгууллага нь шинжээчдээ тасралтгүй байдлаар бэлтгэж, хөгжүүлж сургадаг бөгөөд шинжээчдийг А, В, С гэсэн 3 зэрэглэлд ангилдаг.

Шинжээчийн багийн ахлагчийн эрх, үүрэг нь хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явцыг удирдан, зохион байгуулж, багийн гишүүдийн үүрэг хариуцлагыг хуваарилах, багийн хурлыг удирдах, шинжээчийн багийн гишүүдийн үнэлгээний тайланг нэгтгэж, хугацаанд нь Ажлын албанд хүлээлгэн өгөх, ажлын албанаас өгсөн санал, дүгнэлтийг үндэслэн шинжээчийн үнэлгээний тайланг сайжруулах, шинжээчийн үнэлгээний тайланг Магадлан итгэмжлэлийн комисс, мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх гэсэн эрх үүргийн хүрээнд ажилладаг.

Шинжээчийн багийн гишүүн нь шинжээчийн үнэлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай нэмэлт мэдээллийг сургуулиас зохицуулагч мэргэжилтнээр дамжуулан гаргуулах, шинжээчийн багийн ажлын болон цагийн хуваарьт өөрчлөлт оруулах санал гаргах, магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой санал бодлоо Ажлын албанд илэрхийлэх, хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангагдах, хөндлөнгийн үнэлгээ хийх аргазүй, удирдамжаар хангагдах, маргаантай асуудлаар Өргөдлийн хороонд өргөдөл, гомдол гаргах, БМИҮЗ-өөс зохион байгуулж буй шинжээчийн сургалтад хамрагдах, шинжээчийн гэрээнд заасан үүргийг бүрэн биелүүлэх, Ажлын албанаас зохион байгуулах шинжээчдэд зориулсан сургалт, хэлэлцүүлэг, уулзалтад оролцох, сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, холбогдох материалуудыг судлан шинжээчийн урьдчилсан үнэлгээ хийж, сургалтын байгууллагад очиж ажиллах төлөвлөгөө боловсруулах, шинжээчийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөө, цагийн хуваарийн дагуу өөрийн хариуцсан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх, шинжээчийн үнэлгээний бие даасан тайлан бичиж, тайлагнах, шинжээчийн үнэлгээний тайланг Магадлан итгэмжлэх комисс, мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх зэрэг үүргийг гэрээнд нарийвчлан тусгасан байдаг.

Ажлын албаны даргын тушаалаар байгуулагдсан шинжээчийн баг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын дагуу шинжээчийн багийн уулзалтыг хийж тухайн сургуулийн өөрийн үнэлгээний тайлан болон сургалтын хөтөлбөрийг авч танилцан ажлаа эхлүүлдэг. Өөрийн үнэлгээний тайланг өөрийн үнэлгээний багийнхан магадлан итгэмжлэх байгууллагаас урьдчилан тогтоосон шалгуурын дагуу бичсэн байна.

Судалгааны арга зүй

Өнөөдрийн байдлаар дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх 7 шалгуур 24 шаардлагатай байна /шинэчлэгдэж байгаа/. Үүнд:

Шалгуур 1.Хөтөлбөрийн төлөвлөлт, Шалгуур 2.Сургалтын үйл ажиллагаа, Шалгуур 3.Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл, Шалгуур 4.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, Шалгуур 5.Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа, Шалгуур 6.Багшийн үйл ажиллагаа, Шалгуур 7.Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Эдгээр 7 шалгуураас бид гурван шалгуурыг сонгон авч энэ судалгааны хамрах хүрээг тогтоон шинжилгээний ажлыг хийхээр зорьсон. Шалгуур тус бүр шаардлагаас бүрдэнэ. Дор сонгож авсан 3 шалгуурыг танилцуулъя. Үүнд:

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт: Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.Тус шалгуур нь хөтөлбөрийн төлөвлөлтийг ямар байдлаар хийсэн ингэхдээ холбогдох бодлогын бичиг баримтуудад нийцүүлж, нийтлэг шаардлагуудыг баримталсан эсэх мөн сайжруулалтыг тогтмол хийдэг эсэх сайжруулалтад талуудын оролцоо байдаг эсэхийг тодруулах зорилготой шалгуур бөгөөд 3 шаардлагаас бүрдэнэ.

*Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа :*Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна. Тус шалгуур нь хөтөлбөрийн агуулга, сургалтын арга зүй, үнэлгээ нь суралцахуйн үр дүнтэй хэрхэн нийцэж буйг тодорхойлох зорилготой шалгуур юм.

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа: Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.Тус шалгуур нь суралцагчийн үйл ажиллагаа руу илүү чиглэсэн шалгуур бөгөөд суралцагч оюутан болж элсэхээс эхлэн тэдний сайн дурын үйл ажиллагаа, зөвлөн туслах үйлчилгээ, оролцоог урамшуулдаг эсэх, шилжилт хөдөлгөөнийг суралцагчийн эрх ашигт нийцүүлэн зохион байгуулдаг эсэх, төгсөлтийн бичиг баримт олгох талаар тодруулсан шалгуур юм.

Магадлан итгэмжлэх үйл ажиллагааг эхлүүлэхдээ магадлан итгэмжлэх байгууллага болон тухайн сургалтын байгууллага, магадлан итгэмжлэх байгууллага болон тухайн шинжээчийн багийн хооронд гэрээ байгуулж нууцлалыг хангадаг. Тиймээс энэ судалгаанд сургууль, хөтөлбөрийн нэр, тухайлсан нарийн мэдээлэлгүйгээр зөвхөн сонгож авсан 3 шалгуурын датаг авч ашиглах зөвшөөрлийг БМИҮЗ-ийн удирдлагаас авсан. Судалгаанд 2022 онд сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд ажилласан 20 шинжээчийн багийн тайлангуудаас санамсаргүй түүврийн аргаар 3 шалгуурын дата мэдээллийг авсан.

Тайлангийн агуулгад дараах шалгуурын дагуу шинжилгээ хийсэн. Үүнд:

1. Тухайн шалгуурын хүрээнд анхаарах асуудал, зөвлөмж, шаардлага нийцсэн байдал,
2. Анхаарах асуудал, зөвлөмж, шаардлагад нийтлэг дурдагдсан зүйлүүдийг давтамж, агуулгаар нь багцлан гаргасан.

Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчийн баг тухайн магадлан итгэмжлүүлж буй хөтөлбөрт ажиллахдаа сүүлийн 5 жилийн тайлан, ирэх жилүүдийн төлөвлөгөө, яг одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж оролцогч сонирхогч талуудтай уулзалтыг зохион байгуулах ба үзэж танилцсан нотлох баримтууд, уулзалт ярилцлага, өөрийн үнэлгээний тайланд тулгуурлан шинжээчийн багийн тайланг илрэл нотолгоо, онцлог зүйл/туршлага, анхаарах асуудал, зөвлөмж, шаардлага гэсэн бүтэцтэйгээр бичдэг. Тайлангаас бид анхаарах асуудал (зайлшгүй анхаарах шаардлагатай асуудал), зөвлөмж (анхаарах асуудалд тулгуурлан сайжруулах ажлыг тодорхой заах ба ямар нэгэн нөхцөл болзол дурдахгүй), шаардлага (ямар үйл ажиллагааг цаашид заавал хийх ёстой талаар нарийн тодорхойлох)-д шинжилгээ хийх юм.

Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг

Бидний шинжилгээ хийсэн нийт 20 сургалтын хөтөлбөрийн тайланд тухайн 3 шалгуурын хүрээнд огт хамааралгүй өгсөн зөвлөмж нийт зөвлөмжийн 14.7 хувь байсан бөгөөд 6 шинжээчийн тайланд анхаарах асуудлыг бичээгүй боловч маш олон зөвлөмж өгсөн, анхаарах олон асуудлыг тайланд бичсэн ч зөвлөмж бичээгүй 14 шаардлага, анхаарах асуудал зөвлөмжийг хольж бичсэн 9 шаардлага байна. Мөн хэсэгчлэн хангасан байхад шаардлага бичээгүй 4 шаардлага байсан. Шинжээчийн багийн анхаарах асуудал, зөвлөмж, шаардлагыг тухайн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид 5 жилийн хугацаанд заавал хэрэгжүүлэх ёстой байдаг тул шинжээчид тайлангаа бичихдээ сургалтын хөтөлбөрт өгөөжтэй байдлаар тодорхой зөвлөж өгөхийг магадлан итгэмжлэх байгууллагын зүгээс шаарддаг.

Тухайн шалгуурт хамааралгүй тайлагнасан анхаарах асуудал, зөвлөмжийг 3 шалгуурын хүрээнд жишээгээр танилцуулбал (Хүснэгт 2):

Хүснэгт 2

Шалгуурт хамааралгүй өгсөн анхаарах асуудал, зөвлөмж

Д/д	Тайлагнасан шалгуур, шаардлага	Тайланд тусгасан хэсэг	Хамаарах шалгуур, шаардлага
1	1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага /Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна./	Зөвлөмж - "...сургалтын хөтөлбөрийн хүрээнд төрийн ба төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгжүүдэд 7, 10 хоногоор сургалт, үйлдвэрлэлийн дадлагыг хийлгэж, суралцагчдын чадамжийг нэмэгдүүлэх"	2.1

2	2.3 Суралцагчийн үнэлгээ /Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна./	Анхаарах асуудал - Төгсөгчдийн ажлын байртай холбоотой мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах болон эргэх холбоог сайжруулах	4.2
3	5.1 Суралцагч сонгох, элсүүлэх /Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна./	Анхаарах асуудал - Ерөнхий эрдмийн хичээлүүдийн багш сонголт хийх боломж хомс.	2.1

Бид дараагийн хэсэгтээ тухайн тайлангуудад анхаарах асуудал, зөвлөмж, шаардлагад нийтлэг дурдагдсан зүйлүүдийг давтамж, агуулгаар нь багцлан их, дээд сургуулиудад ажилласан шинжээчдийн тайланд нийтлэг байгаа асуудлыг шалгуур тус бүрээр илрүүлэхээр зорьсон. Үүнд:

Шалгуур нэг хөтөлбөрийн төлөвлөлтийн тухайд нийт тайлангийн 33.2 хувьд нь хөдөлмөрийн зах зээлийн шинэ нөхцөл байдал, өөрчлөлт, эрэлт хэрэгцээг хөтөлбөрийн сайжруулалтад тусгаж хэвшихийг зөвлөсөн байна. Энэ нь сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгчид хөтөлбөрөө боловсруулах болон сайжруулахдаа хөдөлмөрийн зах зээлийн судалгааг бага хийж байгаатай холбоотой юм. Энэ талын зөвлөмж анх удаа хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж буй сургалтын хөтөлбөрүүдэд өгсөн зөвлөмжид нийтлэг байна. 2 болон 3 дахь удаагаа сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж буй хөтөлбөрүүдэд энэ талын зөвлөмж бага байна. Үүнээс харахад магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу хөтөлбөрүүдэд сайжруулалт хийгдэж байгаа нь харагдаж байна.

Дэлхийн топ сургуулиудын хөтөлбөрүүдийг жишиг болгон харьцуулалтыг тогтмол хийх асуудлыг нийт тайлангийн 14.5 хувьд зөвлөсөн бол 45.6 хувьд нь дотоодын их дээд сургуулиудын ижил хөтөлбөртэй харьцуулахдаа сургалтын төлөвлөгөөний хичээл бүрийн агуулгатай уялдуулж дүн шинжилгээ хийж хөтөлбөрөө сайжруулахыг зөвлөсөн нь харьцуулалт дүн шинжилгээг өөрийн сургалтын хөтөлбөрт илүү хэрэгтэй байдлаар хийх шаардлагатай байгааг харуулж байна. Мөн олон улсын хөтөлбөрүүдтэй харьцуулсан гэж өөрийн үнэлгээний тайланд бичигдсэн боловч харьцуулалтын талаарх мэдээ, баримтыг тайланд тодорхой тусгаагүй, нотлох баримт байхгүй байгаа тул бодитоор хийж хэвшихийг 3 хөтөлбөрийн шинжээчийн тайлангийн анхаарах асуудалд бичсэн байна. Энэ нь магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн сүүлийн 5 жилийн нотлох баримтад тулгуурлаж бичээгүй тухайн шаардлагыг хангахын тулд бичсэн гэж ойлгогдож байна. Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа нь сургууль өөрийн хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтээ анхаарч цаашид сайжруулах боломжийг олгодог, хөтөлбөр хэрэгжүүлэгчид хамтаараа баг болон ажиллаж өнгөрсөн хийгээд одоогийн хэрэгжилт цаашдын хөгжлөө цуг нэг түвшнээс харах боломж олгодог

зэрэг олон давуу талтай байдаг. Тийм учраас сургуулиуд өөрийн үнэлгээний тайлангаа бодитоор, нотлох баримтад тулгуурлан бичиж өөрөө өөрсдөдөө бодит үнэлгээ өгч хэвших шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг хөтөлбөрт тусган тогтмол сайжруулдаг байх, хөтөлбөрийн зорилго зорилтыг талуудын оролцоо болон хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгаанд үндэслэн тогтмол сайжруулдаг байхыг 20 хөтөлбөрийн 14-т зөвлөмж өгсөн байгаа нь хөтөлбөрийн боловсруулалт, сайжруулалтад оролцогч талуудын оролцоо хангалтгүй байгааг илтгэж байна. Гэвч нөгөө талаас хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багийн гишүүд өөрийн үнэлгээний тайлангаа бичихдээ оролцогч талуудын оролцооны талаар нотлох баримтуудыг дутуу цуглуулсан, тайланд тусгаагүй эсвэл энэ талаар ажил хийгдээгүй зэрэг шалтгаанууд байж болох юм. Мөн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд хуудасны тоо заадаг, өөрийн үнэлгээний багийн гишүүд өөрийн мэдэж буй мэдээллийн хэмжээгээр тайланг бичсэн зэргээс шалтгаалж бичигдээгүй орхигдсон тал ч байж болох юм. Сургуулиуд хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг бичихдээ ихэвчлэн 2-3 багш нэг шалгуурыг хариуцах байдлаар баг болгон хуваадаг. Тухайн хариуцаж авсан багийн багш нарын хүрээнд тайланг бичиж, эцэслэх нь өрөөсгөл байдаг тул өөрийн үнэлгээний нийт багийн хэмжээнд 7-14 хоногт нэг удаа хэлэлцүүлж бусад багш нартаа мэдээлэл өгч /шинэ багш нарт/, хөтөлбөрт олон жил багшилсан туршлагатай багш нараас нэмэлт мэдээлэл авах нь олон талын давуу талыг бий болгодог.

Хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах, агуулгын давхардлыг арилгах талаар нийт 20 хөтөлбөрийн 7-д зөвлөмж өгсөн байна. Энэ нь 1 дүгээр улиралд үзэх онолын гол хичээлийг 3 дугаар улиралд оруулсан, зарим багш нарын хичээлийн агуулга давхардсан зэрэг анхаарах асуудлуудтай байна. Эдгээр нь цаашид хөтөлбөрийн төлөвлөлтөд анхаарах нийтлэг асуудал болж байна.

Шалгуур хоёр сургалтын үйл ажиллагаа шалгуурын тухайд анхаарах асуудалд цар тахлын цаг үеийн байдлаас үүдсэн онлайн сургалтад лаборатори хичээлүүдийг хэрхэн үр өгөөжтэй зохион байгуулах талаар нийт тайлангийн 8.5 хувьд нь зөвлөмж өгсөн байна. Энэ нь цар тахлын цаг үеийн шинжтэй орж ирсэн зөвлөмж байна. Мөн хичээлийн агуулгын давхардлын талаар шинжээчдийн өгсөн зөвлөмж 10.4 хувьтай байгаа нь агуулга хоорондын давхардал ихтэй байгаатай холбоотой байна. Тухайн мэргэжилтэнд байх ёстой хандлагыг хэрхэн яаж төлөвшүүлж түүнийгээ хэрхэн үнэлж байгаа талаар шинжээчид зөвлөмж өгсөн байсан бөгөөд цаашид хөтөлбөрийн сайжруулалтад зайлшгүй тусгах шаардлагатай байгаа нь харагдсан. Мэргэжлийн лабораторийн хичээлийн багаж тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж шинэчлэн тоноглох, лабораторийн хичээлийн хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар 10.3 хувьд, багшийн арга зүйн сургалтуудыг зохион байгуулах талаар 5.3 хувьд нь тус тус зөвлөмж өгсөн байна.

Шалгуур тав суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа шалгуурын тухайд оюутныг тухайн мэргэжилд нь шаардлагатай зарим сэтгэлзүйн онцлог чанарыг хөгжүүлэх талаар нийт зөвлөмжийн 8.5 хувьд, суралцахын зэрэгцээ хөдөлмөр эрхлэх боломжоор хангах ажлыг бодлогоор зохицуулах талаар 10.5 хувьд нь тус

тус зөвлөмж өгсөн байна. Оюутныг суралцах хугацаандаа түр ажил эрхлэх боломжийг олгох талаар зөвлөмж өгсөн байгаа ч бодлогоор дэмжих асуудал нь сургуулийн хувьд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байж болох тул шинжээчид бодит зөвлөмж өгөх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Шинжээчийн өгсөн зөвлөмжийг тухайн хөтөлбөр хэрэгжүүлэгч дараагийн магадлан итгэмжлэлд орох хүртэлх хугацаанд хэрэгжүүлж 2 жил тутамд аль зөвлөмжийг хэрэгжүүлсэн болох ахиц дэвшлийн тайлангаа өгдөг талаар бид дээр тайлбарласан. Тэгэхлээр шинжээчийн өгч буй зөвлөмж нь тухайн хөтөлбөр хэрэгжүүлэгчид шууд засаж сайжруулж болохуйц зөвлөмж байх хэрэгтэй юм. Оюутнуудын судалгаа шинжилгээний ажлын оролцоог нэмэгдүүлэх талаар нийт тайлангийн 30.2 хувьд нь зөвлөмж өгсөн байгаа нь их дээд сургуулиудын хувьд нийтлэг анхаарах асуудал болоод байна.

Оюутны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүгнэж, үнэлж хэвших талаар анхаарах асуудлын 20.3 хувийг эзэлж байна. Их сургуулиудын хувьд сургалтын цахим платформуор дамжуулан улирал бүрийн төгсгөлд авч байгаа бол дээд сургуулиудын хувьд төдийлөн тогтмолжоогүй хэрэглүүр төдий байгаа нь тайлангуудаас харагдаж байгаа юм. Гэвч зарим их сургуулийн хувьд авсан судалгааныхаа үр дүнг тооцдоггүй, сайжруулалтад ашигладаггүй зэрэг асуудлууд байгаа нь чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоо нь төлөвшөөгүй хэрэглүүр төдий байгаа нь харагдаж байна.

Оюутны сайн дурын үйл ажиллагааг дэмжих удирдлага, санхүүжилтийн төлөвлөгөө, төсвийг боловсруулж ажиллах талаар 13.5 хувьд, тэтгэлэг олгодог байгууллагуудын тоог олон болгох тал дээр анхаарч салбарын яам, агентлаг, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжтэй хамтарч ажиллах 13.5 хувьд тус тус зөвлөмж өгсөн байгаа нь оюутнуудад олгох тэтгэлгийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Сургалтын албатай хамтран оюутны шилжилт хөдөлгөөн болон хичээл завсардалтын шалтгаанд дүн шинжилгээ дүгнэлт хийх 20.5 хувьд давтагдаж байгаа нь хөтөлбөрүүдийн хэмжээнд анхаарах бас нэг чухал асуудал болоод байна. Оюутны клубийн үйл ажиллагаагаар гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлж, кредит тооцох ажлыг журамлан зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх зөвлөмжийг 15.5 хувьд, дипломд бичигдсэн мэргэжлийн хичээлүүдийн англи хэлний орчуулгуудыг сайжруулж олон улсад нийтлэг, хүлээн зөвшөөрөх тал дээр хүндрэл үүсэхээс сэргийлэх талаар 8.5 хувийн зөвлөмжийг тус тус нийтлэг өгсөн байна.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд тулгуурлан бид дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Өөрийн үнэлгээний багийнхан өөрөө өөрсдийгөө үнэлж бичиж буй өөрийн үнэлгээний тайланг өөрсдийн үйл ажиллагааг бүрэн судалж, нотлох баримтдаа тулгуурлан бичдэггүй, сургуульд ажиллах үеэр тайланд тусгаагүй ч нотлох баримтаар маш олон хийгдсэн ажлууд гарч ирдэг эсрэгээрээ тайланд бичигдсэн ч нотлох баримт байхгүй ажлууд байгаа талаар шинжээчид анхаарах асуудалд бичсэн байна. Цаашид магадлан итгэмжлэх үйл ажиллагааг өөрийн хөтөлбөрийн давуу, сул талыг танин мэдэж, сайжруулах боломж болгон харах, тайланг бичих явцдаа нотлох

баримтад тулгуурлах, өөрийн үнэлгээний багийн хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулахыг зөвлөсөн.

- Хөндлөнгийн шинжээчдийн өгч буй зөвлөмж, шаардлага нь тухайн шалгуурын хүрээнд төдийлөн хамааралтай бус өөр шалгуурт хамаарах, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зарим зөвлөмжүүд өгсөн. Мөн зөвлөмж, анхаарах асуудлыг хольж бичсэн байгаа нь шинжээчдийг чадавхжуулах шаардлагатай байгааг харуулж байна.
- Оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг хөтөлбөрийг боловсруулах, сайжруулах явцад оруулж хэвших нь хөтөлбөрийг сайжруулахад чухал ач холбогдолтой байна. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжүүд хөтөлбөрөө анх боловсруулахаас эхлээд шинэчлэх сайжруулахдаа энэ хөтөлбөрөөр дэлхийд төдийгүй улсдаа тэргүүлж буй сургалтын хөтөлбөрүүдтэй харьцуулах, энэ чиглэлийн мэргэжилтэнд тавигдаж буй олон улсын төдийгүй дотоодын шаардлагыг судлах зэрэг харьцуулсан шинжилгээг хийдэггүй. Хөдөлмөрийн зах зээлийг судалдаггүй зэрэг асуудал нь анх удаа хөтөлбөрийн магадланд орсон хөтөлбөрүүдийн зөвлөмжид нийтлэг байна.
- 2018 оноос эхэлсэн чанарын дотоод баталгаажуулалтыг сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад 7 дугаар шалгуураар оруулсан нь их, дээд сургуулиудад чанарын дотоод баталгаажуулалтын журамтай байх, холбогдох нэгжийг бий болгох зэргээр үр дүнгээ үзүүлсэн байна. Гэвч зөвхөн 7 дугаар шалгуураар оруулсан нь сургалтын үйл ажиллагаанаас тусдаа мэтээр хөтөлбөрүүд зөвхөн тухайн шалгуурыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж байгаа тул сургалтын хөтөлбөрийн шалгуур шаардлагыг цаашид шинэчлэхдээ шалгуур бүрд чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг оруулж өгөх. Ингэснээр чанарын баталгаажуулалтын тогтолцоо хэрэглүүр төдий бус соёлын хэмжээнд зөв төлөвшүүлэх боломжтой гэж үзэж байна.
